

## **Төслийн нэр: Дархан сум 8 дугаар баг Дэвшил**

### **“Эко хүүхдийн тоглоомын талбайн” ногоон байгууламжийн төсөл**

#### **Төслийн үндэслэл**

Хот суурин газрын хүүхдийн тоглоомын талбай нь аюулгүй, эрүүл, байгальд ээлтэй орчин байх шаардлагатай. Ногоон байгууламж бүхий тоглоомын талбай нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүй, амралт чөлөөт цагийг зөв өнгөрүүлэхэд чухал нөлөөтэй. Иймээс хүүхдэд ээлтэй, тоосжилт багатай, мод бут сөөгөөр тохижуулсан орчныг бий болгох зорилгоор энэхүү төслийг боловсруулав.

#### **Төслийн зорилго**

Хүүхдийн тоглоомын талбай орчимд ногоон байгууламж бий болгож, аюулгүй, цэвэр, эрүүл орчныг бүрдүүлэх.

#### **Төслийн зорилтууд:**

- Тоглоомын талбайн орчныг мод
- Бут, цэцгээр тохижуулах
- Тоосжилт, хөрсний элэгдлийг бууруулах
- Хүүхдэд сүүдэр, тав тухтай орчин бий болгох
- Иргэд, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх

#### **5. Төслийн байршил**

Байршил: *Дархан 8 баг Дэвшил*

Талбайн хэмжээ: 400м<sup>2</sup>

Хэрэгжүүлэх хугацаа: 1 сар

#### **6. Хийх ажил**

##### **Ажлын төрөл:**

1. Газрын цэвэрлэгээ 1 удаа
2. Хөрс боловсруулах 300 м<sup>2</sup>
3. Зүлэг тарих 300 м<sup>2</sup>
4. Мод тарих 20 ширхэг
5. Цэцгийн мандал байгуулах 200ш

## **7. Тарих ургамлын төрөл, мод**

1. Нарс
2. Ботуул(Амьд зүлэг олон наст)
3. Таримал цэцэг

## **8. Төсвийн тооцоо**

**Мод суулгац 2750000 төг**

**Зүлэг 4637500 төг**

**Ажиллах хүч 1160000 төг**

**Цемент хучилт хуулах 2160000 төг**

**Бусад зардал 1487500 төг**

**Нийт төсөв 12.195.000 төг**

### **Хүлээгдэж буй үр дүн:**

Төслийг хэрэгжүүлснээр хүүхэд аюулгүй, цэвэр орчинд тоглож хөгжих нөхцөл бүрдэж, мод бут сөөг нэмэгдсэнээр орчны тоосжилт буурч агаарын чанар сайжрахын зэрэгцээ ногоон байгууламжийн хэмжээ өсөж, иргэдийн хамтын оролцоо болон байгаль хамгаалах ухамсар, зөв хандлага улам нэмэгдэнэ.

### **Тогтвортой ажиллагаа**

- Усалгаа, арчилгааг СӨХ хариуцна
- Иргэдийн сайн дурын бүлэг ажиллуулна

### **Дүгнэлт**

Энэхүү төсөл хэрэгжсэнээр хүүхэд тоглох аюулгүй, цэвэр, ногоон орчин бүрдэж, хүүхдийн эрүүл мэндэд зэрэг нөлөө үзүүлэхээс гадна тухайн орчны өнгө үзэмж, тохижилт, экологийн нөхцөл мэдэгдэхүйц сайжрах ач холбогдолтой. Мөн мод, ногоон байгууламж нэмэгдсэнээр тоосжилт буурч, агаарын чанар сайжрахын зэрэгцээ иргэдийн оролцоо, байгаль орчноо хайрлан хамгаалах зөв хандлага нэмэгдэж, цаашид тогтвортой, эрүүл орчныг бий болгоход чухал хувь нэмэр оруулна.

**Дэвшил 8 дугаар баг “Ногоон байгууламж тохижилтийн ажлын задаргаа”**

**1.Хөрс хуулалт (Бетон)**

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Экскаватор	4 цаг	250,000₮	1,000,000₮
2	Хово	2 зөөвөр	400,000₮	800,000₮
3	Налуугийн хавтан	30ш	12,000₮	300,000₮
4	Ажилтан (Наах хавтан)	2хүн	150,000₮	300,000₮
5	Хоол, хүнс	2 хүн	15,000₮	30,000₮
<b>Нийт үнэ</b>				<b>2,430,000₮</b>

**2.Зүлэгжүүлэлт**

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хар шороо	5 портер	250,000₮	1,250,000₮
2	Элс	5 машин	100,000₮	500,000₮
3	Үр(Олон наст ботуул)	80кг	33,000₮	2,640,000₮
4	Түлш	50л	4,950₮	247,500₮
5	Хоол, хүнс (2 өдөр)	4 хүн	15,000₮	800,000₮
6	Ажилчин(2 өдөр)	4хүн	85,000₮	680,000₮
<b>Нийт үнэ</b>				<b>6,047,500₮</b>

### 3.Мод тарих

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Нарс мод	14ш	80,000₮	1,120,000₮
2	Модны хайрцаг	14ш	50,000₮	700,000₮
3	Хар шороо	1 портер	250,000₮	250,000₮
4	Бууц	1 портер	150,000₮	150,000₮
5	Ус түлш	20л	4,950₮	99,000₮
6	Ажилчин	4хүн	80,000₮	320,000₮
<b>Нийт үнэ</b>				<b>2,631,000₮</b>

### 4.Цэцгийн мандал

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Цэцэг мандал	150ш	2500₮	375,000₮
2	Мандал хайрцаг	3ш	120,000₮	360,000₮
3	Хар шороо	1 портер	250,000₮	250,000₮
4	Будаг	1ш	20,000	20,000₮
5	Бусад			83,500
<b>Нийт үнэ</b>				<b>1,088,500₮</b>